

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ЗАНАЛХИЙЛЭЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

THREATS AGAINST CHILDREN IN CYBER SPACE, ITS PREVENTION



Д.СУМЬЯЦЭРЭН

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахлах дэслэгч

SUMIYATSEREN D.

Researcher of Police studies center, Research and Development institute, Law enforcement university, Police senior lieutenant

Товч агуулга: Цахим орчинд хүүхдийг отоож байж болох аюул заналын талаар зарим нэр томъёог тайлбарлаж, гэмт этгээдүүд тухайн гэмт хэргийг хэрхэн үйлддэг талаар, мөн энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тус өгүүлэлд бичжээ.

Abstract: The article is about cyber crime against the children and how to protect them. In this article explain some of the terms of cyber crimes against children in cyber space and how the offender commit a crime, and about the prevention of this crime.

Түлхүүр үгс: Кибер гэмт хэрэг, цахим орчин, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг кибер гэмт хэрэг.

Key words: Cyber crime, cyber space, child protection, cyber crime against the children.

Сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны технологи буюу интернетийн сүлжээ, гар утасны технологи, интернетэд холбогддог төхөөрөмж, техник хэрэгсэл олширсон нь асар их мэдээллийн санг бий болгож байгаа төдийгүй бидэнд, бидний үр хүүхдүүдэд ч суралцах, бусадтай харилцах, мэдээлэл авах ба солилцох, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг арвин их боломжийг нээж өгсөн. Интернетийн хэрэглээ нь нийгмийн үйлчилгээ, сургалтын материал, эрүүл мэндийн талаарх зэрэг олон төрлийн мэдээллийг цаг алдалгүй авах боломжийг олгож байгаа хэдий ч тэр хэрээрээ маш олон эрсдэлийг дагуулж байдаг. Тухайлбал, хүүхэд өөрийн насанд тохироогүй буюу садар самуун мэдээлэл олж үзэх, бусдад залилуулах, бэлгийн хүчирхийллийн бай болох, гэмт

этгээдүүдтэй харилцаа холбоо тогтоох зэрэг маш олон эрсдэл бий.

Манай улс 1990 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэгдэн орж, 1996 онд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийг баталснаар хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн. “Хүүхдийн эрхийн тухай” болон “Хүүхэд хамгааллын тухай” хууль энэ оны хоёрдугаар сарын тавны өдөр батлагдсантай холбогдуулж “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг хүчингүй болсонд тооцохоор заасан бөгөөд үүнийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон билээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” гэх 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн





ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална”¹ заасан байдаг. Харин тус зүйлийн 8.2 дахь хэсэгт “Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээллэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана” гэж зааж өгчээ. Энэ ч үүднээсээ хүүхдийг цахим орчинд отож байж болох тодорхой эрсдэлүүдээс тухайлан авч тайлбарлахыг зорьлоо.

Цахим сүлжээнд хүүхдийг эргүүлэх гэдэг нь хүүхдийг бэлгэсийн үйл ажиллагаанд хууран мэхлэх замаар оруулах, ятгах ажиллагааг хэлдэг бөгөөд бэлгэсийн үйл ажиллагаа гэдэг нь биечлэн уулзаж үйлдэх ажиллагаагаар хязгаарлагдахгүй, веб камераар дамжуулан хүүхдийг ашиглах, садар самуун бүтээгдэхүүнд оролцуулах, бэлгэсийн агуулгатайгаар өөрийнх нь зураг, дүрсийг хийлгэж авах зэрэг үйлдлийг багтаадаг байна.² “Эргүүлэх” гэдэг нэршил нь олон улсын хуульд тусгагдаагүй бөгөөд Канад зэрэг зарим улсын хууль тогтоомжид “уруу татах” гэх нэршлийг хэрэглэдэг байна.³

Гэмт этгээдийн сэдэл нь бэлгийн гаж сонирхол, эсвэл санхүүгийн ашиг байдаг ба гэмт этгээд ганцаараа, эсвэл сүлжээ болж ажилладаг байна. Гэмт этгээдүүд хүүхдийн эмээг, итгэмтгий байдал, эцэг эхийн хяналт зэрэг дээр үнэлгээ хийсний үндсэн дээр хохирогч хүүхдийг сонгодог. Тэд ихэвчлэн цахим сүлжээн дэх чатын хуудас, тоглоомын болон

нийгмийн сүлжээний веб талбарыг ашиглан хүүхэдтэй харьцах боловч цахим бус орчинд ч хүүхэд эргүүлэх тохиолдол гардаг байна.

Гэмт этгээдүүд ихэвчлэн хүүхдийн итгэлийг олохын тулд сэтгэл хөдлөлд суурилсан харьцаа үүсгэдэг бөгөөд анхаарал тавих, бэлэг өгөх зэргээр хүүхдийн дутагдаж байгаа хэрэгцээг нөхөх, эсвэл сэтгэл зүйн дарамт үзүүлэх, башир аргаар хууран мэхэлж ятгах, бэлгэсийн үйлдлийн талаар сургамжлах, сэрэмжийг нь сулруулах зэрэг үйлдлийг ашигладаг байна. Мөн хүүхдийг бэлгийн харилцаанд татан оруулахын тулд өөрийгөө нууцалж, өөр хэн нэгэн хүний дүрд тоглох тохиолдол ч байдаг ба хүүхэдтэй тогтоосон харилцаагаа алхам алхмаар садар самуун шинжтэй болгодог.

Сүрдүүлэг (sextortion) гэж бусдыг бэлгийн харилцаанд албадан оруулах, мөнгө, бусад эд бараа шаардаж авах, садар самуун бүтээгдэхүүн хийхэд албадах үйлдлийг ойлгоно. Сүрдүүлэг нь гэмт этгээд ба хохирогчийн хүч чадал, эрх мэдлийн тэгш бус байдлаар тодорхойлогдох ба энэ нь хохирогч гэмт этгээдийн садар самуун шаардлага болон мөнгө нэхсэн үйлдэлд автах нөхцөл болдог.

Гэмт этгээд шууд биечлэн хүч хэрэглэхээс илүү эрх мэдэл, давуу байдлаа ашиглан хохирогчийг бэлгэсийн үйл хийхийг зөвшөөрүүлэх, мөнгө, бусад эд бараа өгөх шаардлагад автахад хүргэдэг байна. Сэтгэл зүйн сүрдүүлэг нь шаардлагыг биелүүлэхгүй бол тодорхой ашиг сонирхлыг нь барьцаалах, эсвэл хүсэшгүй үр дагаварт хүргэх үйлдлээр далайлган сүрдүүлэхэд оршдог. Садар самуун бүрэлдэхүүн нь хүүхдийн хүсээгүй аливаа хэлбэрийн бэлгэсийн үйлдлийг шаардах, жишээлбэл, биеийн хэсгүүдийг ил гаргаж үзүүлэх, садар самуун гэрэл зураг авахуулах, биечлэн хүчирхийлэл үйлдүүлэхийг шаардах зэргээр албаддаг байна. Мөн хохирогчоос эд

¹ <http://legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

² ЕСПАТ Олон улсын байгууллагын Цахим сүлжээнд хүүхдийн бэлгэсийн мөлжлөгтэй тэмцэх хөтөлбөрөөс.

³ http://www.unicef.org/pacificislands/ict_eng.pdf



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УНДГАВЬ

бараа, үйлчилгээ, мөнгө шаардан авч байгаа аргад нь тусгалаа олж болно. Жишээлбэл, гэмт этгээд хохирогчийн өөрийнх нь бэлгэсийн агуулгатай дүрс, зургийг олж аваад, түүнийг нь илчлэхээр сүрдүүлж мөнгө нэхэж болно. Түүнчлэн хохирогчийн өөрийгөө зохисгүй байдлаар авсан дүрс, зургийг цахим сүлжээгээр түгээх, эсвэл үе тэнгийнхэнд нь илгээх гэх мэтээр сүрдүүлэг хийж болно. Тийнхүү илгээсэн нь хохирогч хүүхдийг дээрэлхүүлэх, дарамтлуулах зэрэг давхар хор нөлөөлөлд өртөхөд хүргэдэг байна.

Кибер доромжлол гэдэг ойлголт нь олон улсын хуулиар тодорхойлогдоогүй. Харин Олон улсын цахилгаан холбооны байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сангаас 2014 онд эрхлэн гаргасан "Онлайн орчинд хүүхдийг хамгаалах тухай мэдээлэл, харилцаа холбооны технологийн удирдамж"-д кибер доромжлол гэдгийг санаатай, олон удаагийн үйлдлээр компьютер, гар утас болон бусад цахим хэрэгслээр дамжуулан хохирол учруулахыг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд энэ нь шууд хэлбэрээр (жишээ нь, чат, мессеж), тодорхой хүмүүсийн хүрээнд (жишээ нь, цахим шуудангийн хаягийн жагсаалтад доромжилсон мессеж илгээх), эсвэл олон нийтийн мэдээллийн сүлжээгээр (жишээ нь, хохирогчоор доог тохуу хийсэн цахим хуудас бүтээх) явагддаг.⁴

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн материал гэдэг нь шууд бэлгийн зорилгоор хүүхдийг оролцуулсан садар самуун кино, гэрэл зураг, сэтгүүл, видео бичлэг, зурсан зураг, хүүхэлдэйн кино, текст, шууд бичлэг зэрэг аливаа уйл ажиллагаа болон үзүүлбэрийн бэлгийн үйлдлийн хэсгийг бодит байдлаар болон дуурайн үзүүлсэн хэлбэрээр илтгэн харуулсныг хэлнэ.⁵ "Хүүхдийн садар самуун" гэдэг

⁴http://cyber.law.harvard.edu/sites/cyber.law.harvard.edu/files/RAB_Lit_Review_121808_0.pdf

⁵ Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай нэмэлт протокол болон Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах Европын Зөвлөлийн конвенц.

нэршил нь ихэвчлэн хууль эрх зүй, олон улсын конвенцид хэрэглэгддэг боловч уг нэршил нь онлайн орчинд хүүхдийг хамгаалах тухай удирдамжид хэрэглэгдээгүй. Учир нь "садар самуун" гэдэг нь ихэвчлэн өөрийн дур хүслийн дагуу бэлгийн харилцаанд орж буй насанд хүрсэн хүмүүс хоорондын үйлдэл, харилцааг хэлдэг гэсэн нийтлэг ойлголт байдаг. Ийм учраас "хүүхдийн садар самуун" гэдэг нэршлийг ашиглах нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг талаас илэрхийлэгдэхгүй, эсвэл хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн материалын талаарх өргөн цар хүрээг багтааж чаддаггүй тул уг нэршлийн хэрэглээ нь буруу ойлголтод хүргэж болох юм.

Эцэг эхийн хяналтын хэрэглүүр Интернет сүлжээнд холбогддог компьютер болон бусад хэрэгслийн програм хангамж нь үйлдлүүдийг бүхлээр нь болон хэсэгчлэн хаах, зохицуулах боломжийг хэрэглэгч буюу эцэг эхчүүдэд олгосон байдаг. Ерөнхийдөө эдгээр програм хангамж нь тодорхой ангиллын буюу хэлбэрийн онайн үйлчилгээ, цахим хуудасны хандалтыг хязгаарлах боломжтой байдаг. Зарим тохиолдолд зөвхөн цаг хугацааг зохицуулах боломжийг олгодог, өөрөөр хэлбэл, төхөөрөмж нь заасан тодорхой цагийн хооронд интернетийн сүлжээнд холбогддог байхаар тохируулж болдог. Илүү дэвшилтэт хэлбэрүүд нь төхөөрөмж хүлээн авсан болон илгээсэн бүх бичвэрийг хадгалж үлдэх боломжтой. Тухайн програм нь нууц үгээр хамгаалагдсан байдаг.⁶

Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд хэрэглэгчдийг хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зураг, дүрс бичлэг зэргийг агуулдаг цахим хуудсуудад нэвтрэхээс хамгаалдаг. Тэдгээр компаниуд хэрэглэгчдээ хүүхдийн бэлгийн хүчирхийлэл бүхий дүрс, материалыг интернетэд

⁶ "Онлайн орчинд хүүхдийг хамгаалах тухай мэдээлэл, харилцаа холбооны технологийн удирдамж". Олон улсын цахилгаан холбооны байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан. 2014. 5 дахь тал.



байршуулах, хоорондоо солилцох, хадгалах үйл ажиллагаа явуулахаас нь сэргийлэх зорилгоор шүүлт болон хязгаарлалт гэх технологийг ашигладаг. Энэхүү технологи нь гэмт этгээдийг хүүхдийн бэлгийн хүчирхийллийн мэдээлэл, материалруу хандах, тараах үйлдлийг таслан зогсоодог. Мөн зураг, дүрс бичлэгт орсон хохирогч хүүхдүүдэд чухал нөлөө үзүүлдэг нь тухайн зураг, дүрс бичлэгийг шүүж, нэвтрэх боломжгүй болгосноор хүүхдийн хувийн мэдээлэл, нэр хүндийг хамгаалж, хүүхдэд халдаж болзошгүй аюул, заналыг бууруулдаг байна.

Шалиг бичвэр гэж хүүхдүүд илт бэлгэсийн утгатай илгээлтийг зориуд солилцох, өөрсдийнхөө бэлгэсийн агуулгатай дүрс, зургийг бусдад илгээхийг хэлнэ.⁷ Зураг, дүрс бичлэгт нь нүцгэн болон хагас нүцгэн, эротик буюу бэлгэсийн агуулгатай дүрс байх ба ихэвчлэн найз хөвгүүндээ, найз охиндоо, эсвэл үе тэнгийнхэндээ илгээдэг байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхэд худалдахтай тэмцэх тухай нэмэлт протоколын тодорхойлолтоор хүүхэд ашигласан садар самуун гэдэг нь аливаа арга хэрэгслээр хүүхдийг жинхэнэ буюу дууриамал бэлгийн харьцаанд орж байгаагаар үзүүлсэн, эсвэл садар самуун зорилгоор хүүхдийн бэлгэ эрхтнийг харуулсан зураг, дүрслэл юм. Тухайн агуулгыг нэгэнт цахим сүлжээнд илгээсэн хойно цааш хэрхэн тарж, түгэхийг хянах арга байхгүй юм.

Хүүхэд шалиг бичвэр үйлдэх сэдэл нь бэлгийн харьцааг зугаатай болгох, туршиж үзэх, магтуулах, анхаарал татах, үнэнчээ батлах зэрэг янз бүрийн шалтгаантай байж болно. Мөн үе тэнгийнхний шахалт, ятгалгаас болсон байх ч магадлалтай Хүүхдүүд шалиг бичвэрийнхээ цаашдын хортой үр дагаврыг мэддэггүй, өөрийгөө нууцлах арга хэмжээ авдаггүй тул эрсдэл ихтэй юм. Шалиг бичвэр хүүхдийг сүрдүүлэг,

дарамт, дээрэлхэх үйлдлийн бай болгох аюултай ба тухайн зураг, дүрс нь хүүхдийг садар самуунд ашигласан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглагдах, улмаар эргэлтэд орох эрсдэлтэй байдаг.

Дээр бичсэнчлэн хүүхдийг олон аюул занал цахим орчинд отоож байдаг. Тэдгээрээс онцолбол бидний өдөр тутмын хэрэглээ болсон нийгмийн сүлжээний цахим хуудас болох фэйсбүүк. Энэхүү сүлжээний хэрэглэгчид манай улсад төдийгүй дэлхий дахинд ч өсөн нэмэгдсээр байгаа. Хүүхдүүд тэр дундаа өсвөр насны хүүхдүүд сониуч зандаа хөтлөгдөн элдвийг хайж эрэлхийлдэг, үүнээсээ болж гэмт хэргийн хохирогч болох тохиолдол сүүлийн жилүүдэд их гарах болсон бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Тиймээс бид хүүхэд, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад цахим орчин дахь аюул, занал, түүний үр дагаварыг ухуулан таниулах, ойлгуулах, цахим сүлжээнд шалиг бичвэр, хүүхдийг садар самуунд ашигласан бүтээгдэхүүнтэй таарсан бол холбогдох байгууллагад мэдээлдэг байх, цахим сүлжээнд шалиг бичвэр, хүүхдийг садар самуунд ашигласан бүтээгдэхүүн түгэх явдлыг хязгаарлах чиглэлээр интернет үйлчилгээ үзүүлэгч болон үүрэн холбооны байгууллагатай хамтран ажиллах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын чадавхийг бэхжүүлэх, арга хэрэгслээр хангах, хүүхдүүдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах чиглэлээр интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, тэдэнд шаардлага тавих, ямар нэгэн байдлаар уг гэмт хэргийн хохирогч болсон, эрсдэл бүхий нөхцөл байдал бий болсон даруйд холбогдох хуулийн байгууллагад үнэн зөвөөр мэдээллэх ёстойг тэдэнд ойлгуулах, уг гэмт явдлын талаар хүүхдүүдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, тэдний мэдлэгийг гүнзгийрүүлэх, тэдний ёс зүйн зөв хандлагыг бий болгох шаардлагатай

⁷ ЕСПАТ Олон улсын байгууллагын Цахим сүлжээнд хүүхдийн бэлгэсийн мөлжлөгтэй тэмцэх хөтөлбөрөөс.

байна.

Мөн сургуулийн орчинд ухаалаг техник, хэрэгслийг ашиглах, нийгмийн сүлжээний хяналтгүй хэрэглээг хязгаарлах эрх зүйн төдийгүй ахуйн соёлыг бий болгох шаардлага ч тулгараад байна.

ЭХ СУРВАЛЖ ЖАГСААЛТ

1. ЕСРАТ Олон улсын байгууллагын Цахим сүлжээнд хүүхдийн бэлгэсийн мөлжлөгтэй тэмцэх хөтөлбөр.

2. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай нэмэлт протокол болон Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах Европын Зөвлөлийн конвенц.

3. “Онлайн орчинд хүүхдийг хамгаалах тухай мэдээлэл, харилцаа холбооны технологийн удирдамж”. Олон улсын цахилгаан холбооны байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан. 2014.

Цахим эх сурвалж:

<http://legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

http://www.unicef.org/pacificislands/ict_eng.pdf

http://cyber.law.harvard.edu/sites/cyber.law.harvard.edu/files/RAB_Lit_Review_121808_0.pdf

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн, Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч Б.Энхболд



Хууль сахиулахуй